

4.Үнэлгээний асуулга

Техник импорт ХК

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1.Компани нь ТУЗ-ын үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлдэг	2024 оны 03 сарын 19-ний өдрийн ТУЗ-ын хурлаас компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан. Компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 5,6,8,9,10 дугаар зүйлээр тус тус зохицуулагддаг.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлдэг	ТУЗ-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг баталж компанийн цахим хуудсанд байрлуулсан. Компанийн ТУЗ-ын гишүүнд нэр дэвшүүлэх эсэх асуудал “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн “ТУЗ-ын гишүүнд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх журам”-аар болон тус журмын Хавсралт№4-өөр зохицуулагддаг.	2	100%
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Бүрэн хэрэгжүүлдэг	Журамд заасны дагуу ТУЗ-ын гишүүдийн талаарх холбогдох мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж Хороо болон Хөрөнгийн биржид заасан хугацаанд тогтмол хүргүүлж ажилладаг. Жил бүр холбогдох журамд заасны дагуу “Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан”-д тусгаж Хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлж ажилладаг. Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ын төсвийг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. ТУЗ-ын болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ын нарийн бичгийн даргын ажлын гүйцэтгэлийг үнэлж үнэлгээний тайланг 2024 оны ХЭХ-ын материалын хамт Хороо, Хорооны Комплаенсын хэлтэст болон Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлсэн.	2	100%

			2023 оны компанийн “Жилийн үйл ажиллагааны тайлан”, 2024 оны компанийн “Хагас жилийн үйл ажиллагааны тайлан”, 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланг тус тус Хороо болон Хөрөнгийн бирж ХК-д тус тус хүргүүлж цахим хуудаснаа байршуулсан.		
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлдэг	МУ-ын Компанийн тухай хууль, Компанийн Дүрэмд заасны дагуу компанийн ТУЗ болон ТУЗ-ын дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүдэд тавигдах шаардлага, хүйсийн тэнцвэрт байдал зэргийг “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 2, 3, 4, 8 дугаар зүйлд тодорхой тусгасан. 2024 оны ХЭХ-аас ТУЗ-ын гишүүдийг сонгож баталсан ба ТУЗ-ын нийт 9 гишүүнийг хүйсээр ангилбал эрэгтэй 5, эмэгтэй 4 гишүүн сонгогдсон, нийт гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдсан, мэргэжил, мэргэшлээрээ олон жил ажилласан туршлагатай, компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д заасан шаардлага, ур чадварыг бүрэн хангасан гишүүдээс бүрдсэн.	2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.		Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн зорилго, стратегийн бодлогыг хэрэгжүүлэх, нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангаж ажиллуулах зорилгоор зохих журмын дагуу ТУЗ-ын гишүүнээр анх удаагаа сонгогдсон гишүүн бүрийг компанийн засаглалын сургалтанд хамруулах, компанийн үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журам, баримт материалтай танилцуулах ажлыг зохион байгуулж ажилладаг. Мөн хариуцсан ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхтэй нь холбогдуулан мэргэжил, хороодын чиг үүргийн дагуу гишүүдийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, мэдлэг олгох нөхцөл боломжоор нь хангах, шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн болон шаардлагатай сургалтанд тогтмол хамруулахад шаардагдах төсвийг жил бүрийн ТУЗ-ын төсөвт тусгаж төсвийг ХЭХ-аар батлуулж ажилладаг. ТУЗ-ын болон компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр гишүүдийг цаг тухай бүрд нь хангаж байхад байнга анхаарч ажилладаг ба энэ талаарх асуудал нь “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 5.1.7, 5.1.14, 5.1.15, 5.5, 5.6 дугаар зүйлээр зохицуулагддаг. 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2023 оны ТУЗ-ын тайланг хэлэлцэх асуудлын хүрээнд 2023 оны ТУЗ-ын гишүүдэд зориулсан сургалтын төлөвлөгөөний биелэлтийн үр дүнг хэлэлцэж дүгнэн 2024 оны сургалтын төлөвлөгөөг баталсан. 2024 оны ТУЗ-ын “Сургалтын төлөвлөгөө”-ний дагуу ТУЗ-ын гишүүдийг		

		Бүрэн хэрэгжүүлдэг	холбогдох сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. 2023 оны ТУЗ-ын сургалтын төлөвлөгөөний биелэлт, 2024 оны ТУЗ-ын сургалтын төлөвлөгөөг Хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлсэн. 2024 оны ТУЗ-ын сургалтын төлөвлөгөөний дагуу ТУЗ-ын нийт гишүүд 9 удаагийн сургалтанд хамрагдсан бол ТУЗ-ын нарийн бичгийн дарга 3 удаагийн сургалтанд хамрагдсан.	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	ТУЗ-ын нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82-р зүйл, компанийн “Дүрэм”-ийн 7-р зүйл, компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 9-р зүйлийг үйл ажиллагаандаа удирдлага болгон мөрдөж ажилладаг ба холбогдох хууль, журмыг зөрчсөн тохиолдолд “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 5.4,10.3.4-т заасны дагуу ТУЗ-ын дарга хариуцлага хүлээлгэхээр журамд тусгагдсан. 2023, 2024 оны ТУЗ-ын нарийн бичгийн даргын ажлын тайланг Хороонд тайлагнаж ажилласан. ТУЗ-ын нарийн бичгийн дарга нь хууль, журмаар хүлээсэн үүргийн дагуу заасан хугацаанд Хороо болон МХБ ХК-д компанийн санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргүүлж үүргээ биелүүлж ажилласан ба Техник импорт ХК нь МХБ ХК-д бүртгэлтэй ХК-иудын “2024 оны хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийн судалгаа”-гаар 100 оноотой үнэлэгдсэн.	2	100%
ДҮН				12	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн тухай хуулийн 81.2, компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэхь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1,8.6,8.9 дэхь хэсэгт заасны дагуу Техник импорт ХК-ийн ТУЗ-ын 9 гишүүний 3 нь хараат бус гишүүн ба Хараат бус гишүүд нь ТУЗ-ын дэргэдэх хороодын даргаар ажилладаг. Хороо бүр 3 гишүүнтэй ба хорооны нийт гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүнээс бүрддэг. Хорооноос гарах шийдвэр нь хараат бус гишүүдийн олонхийн саналаар буюу хараат бус гишүүний саналаар баталдаг байхаар холбогдох журамд тусгаж баталсан.	2	100%
8	2.2.ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл		Компанийн ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагаа нь “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар зохицуулагддаг бөгөөд тус		

	ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлдэг	журмын 8 дугаар зүйлийн 8.9-8.17-д заасны дагуу Аудитын хороо үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажилладаг. Компанийн ТУЗ-ын дэргэдэх Аудитын хорооны дарга нь ТУЗ-ын хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг бүрэн хангасан, ТУЗ-ын дарга бус хараат бус гишүүн юм. Аудитын хорооны хуралд компанийн Гүйцэтгэх удирдлага болон компанийн холбогдох ажилтнууд тус хорооны гишүүдийг шаардлагатай тайлбар, мэдээлэл, нотлох баримтаар хангах, санал, хүсэлтээ илэрхийлэх, санал солилцох хэлбэрээр оролцдог.	2	100%
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн ТУЗ-ын дэргэдэх Цалин урамшууллын хорооны үйл ажиллагаа нь “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар зохицуулагддаг бөгөөд “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 8.6,8.7,8.8-д заасны дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажилладаг. Тус хорооны дарга нь компанийн ТУЗ-ын хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг бүрэн хангасан, ТУЗ-ын дарга бус хараат бус гишүүн юм. Цалин, урамшууллын хорооны хүсэлтээр компанийн гүйцэтгэх удирдлага хорооны хуралд оролцдог.	2	100%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаа нь “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар зохицуулагддаг бөгөөд ТУЗ-ын үйл ажиллагааны 8.1,8.2, 8.3,8.4,8.5-д заасны дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажилладаг. ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ын хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг бүрэн хангасан ТУЗ-ын дарга бус хараат бус гишүүн юм. Компанийн ТУЗ-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас компанийн “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг баталсан.	2	100%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн	Бүрэн	1.Компанийн ТУЗ нь дэргэдээ 1. Аудитын хороо 2. Нэр дэвшүүлэх хороо 3. Цалин, урамшууллын хороо		

	<i>дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>	хэрэгжүүлдэг	-той бөгөөд Хороодын үйл ажиллагааны чиглэлийг “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлд тодорхой тусгасан. “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүнд тавигдах шаардлага, болзол хангасан иргэнийг компанийн ХЭХ-аас сонгож ТУЗ-ын гишүүнээр томилж ажиллуулдаг. Жил бүр ТУЗ-ын гишүүдийн мэдлэг, ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч ТУЗ-аас сургалтын төлөвлөгөөг баталж сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлдэг. Компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 13 дугаар зүйлийн 12.5-д ТУЗ нь өөрийн дэргэдэх хороодоос гадна тусгай чиг үүрэг бүхий хороог нэмж байгуулж болохоор тусгасан боловч ТУЗ нь одоогийн нөхцөл байдалд бусад чиг үүрэг бүхий түр хороог байгуулах шаардлагагүй гэж үзэж байгаа болно. 2022, 2023 оны ТУЗ-ын болон ТУЗ-ын дэргэдэх хороодын ажлын тайланг СЗХ болон Хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд хүргүүлж тайлагнасан.	2	100%
ДҮН				10	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бүс тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн ТУЗ-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас “Техник импорт ХК-ийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7.11, 2.8.4, 3 дугаар зүйлийн 3.5.2, 6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.15,8.16,8.17, 9 дүгээр зүйлийн 9.2.5, 10 дугаар зүйлийн 10.3.4, 10.3.15-д тус тус заасны дагуу компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажилладаг. “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-д заасны дагуу компанийн хугацаат тайлан болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг 2023, 2024 онд тогтоосон хугацаанд нь СЗХ, Монголын хөрөнгийн бирж ХК-д тус тус хүргүүлж цахим хуудаснаа байршуулсан. 2024 онд холбогдох журмын дагуу мэдээллийн тайланг гаргаж дүгнэн компанийн холбогдох ажилтнуудад мэдээлж танилцуулсан. Мэдээллийн тайлангийн үнэлгээгээр холбогдох хууль, журмаар хүлээсэн үүргийн хэрэгжилт “Хангалттай сайн” гэж үнэлэгдсэн.	2	100%

13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компани нь өөрийн цахим хуудсандаа холбогдох хууль, журамд заасан хугацаанд компанийн хагас болон жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан, компанийн засаглалын баримт бичиг, дүрэм журмыг бүрэн байршуулж цахим хуудсаараа дамжуулан мэдээллийг олон нийтэд хүргэх үүргээ хариуцлагатай хэрэгжүүлж ажилладаг.	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлдэг	1.Техник импорт ХК нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайланг улирал, хагас болон жилээр нь үнэн зөв гаргаж төрийн эрх бүхий байгууллагууд болон харьяа дүүргийн холбогдох байгууллагад тайлагнаж ажилладаг. 2.Компани нь компанийн “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”, СЗХ, Монголын Хөрөнгийн бирж ХК-ийн холбогдох журамд тус тус заасны дагуу холбогдох мэдээллийг компанийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж баталгаажуулан Хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж компанийн цахим хуудсанд тогтмол байршуулдаг. 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд холбогдох мэдээллийг тусгаж МХБ ХК-ийн цахим хуудсанд байршуулж СЗХ, МХБ ХК-д тогтоосон хугацаанд хүргүүлж тайлагнасан.	2	100%
ДҮН				6	100%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.					

15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.10.4-т энэ талаарх асуудлыг тодорхой тусгаж зохицуулсан ба хэрэгжилтэнд ТУЗ хяналт тавьж ажилладаг. Техник импорт ХК нь холбогдох хууль, журамд заасны дагуу 2024 оны жилийн эцсийн тайландаа СЗХ-нд бүртгэлтэй, аудит хийх зөвшөөрөлтэй Сэрэлт дөл аудит ХХК-иар аудит хийлгэж тус аудитлагдсан талиан, аудитын дүгнэлтийг заасан хугацааны дотор МХБ ХК, СЗХ-нд тайлагнаж ажилласан.	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компани нь жил бүр СЗХ-оос олгосон зөвшөөрөлтэй, Хороонд бүртгэлтэй Аудитын компаниар жилийн эцсийн санхүүгийн тайландаа аудит хийлгэж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ХЭХ-д тайлагнаж хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх үүргээ хэрэгжүүлж ажилладаг. 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан ба энэ чиг үүргийг шинээр оруулж тусгасан. Холбогдох журамд заасны үүргийн дагуу Техник импорт ХК-ийн 2025 оны ХЭХ-д зориулсан Сэрэлт дөл аудит ХХК-ийн аудитын дүгнэлтийг ХЭХ-д мэдээлж танилцуулсан.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.		2012 онд Компанийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан компанийн бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт орж “Дотоод аудитын алба”-ыг анх шинээр байгуулсан. Компанийн ТУЗ болон Дотоод аудитын албаны хоорондын ажлын уялдаа холбоо, ТУЗ-аас дотоод аудитын албаны үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 8.10.3,8.11,8.12,8.13 тодорхой тусгагдсан. Компанийн дотоод аудитын албаны чиг үүрэг, энэ талаарх хийж гүйцэтгэсэн ажлын талаар компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тодорхой тусгаж СЗХ, Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж МХБ	2	100%

		Бүрэн хэрэгжүүлдэг	ХК-ийн сайт болон өөрийн компанийн цахим хуудаснаа байршуулж олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилладаг. 2022 оноос компани нь үйл ажиллагаандаа ISO-9001:2015 удирдлагын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн. Энэ ажлын хүрээнд компанийн удирдлагаас 1.“Чанарын дотоод аудитын журам” 2.“Санхүүгийн дотоод аудитын журам”-ыг тус тус баталж компанийн үйл ажиллагаанд мөрдүүлэн хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны аудитын үйл ажиллагааны тайланг компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж заасан хугацааны дотор МХБ ХК-ийн цахим хуудсанд байршуулж СЗХ, МХБ ХК-д хүргүүлж тайлагнасан.		
ДҮН				6	100%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 2,8.2, 8.10.1, 8.13-т эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны талаар ТУЗ-ын чиг үүрэгт тодорхой тусгаж ТУЗ болон ТУЗ-ын Аудитын хороо хяналт тавихаар зохицуулагдсан. Тайлант хугацаанд компаниас баталсан журмын дагуу компанийн үйл ажиллагаанд эрсдлийг тодорхойлж ТУЗ болон чанарын баг хяналт тавьж ажилласан. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланд эрсдлийн үйл ажиллагааны талаар тусгаж тайлагнасан.	2	100%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан	Бүрэн хэрэгжүүлдэг	ТУЗ-ын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны чиглэлээр ТУЗ-ын Аудитын хороо хариуцан ажиллаж дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулж байх талаар “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 8.10.1 дэхь хэсэгт заасан. ТУЗ-ын Аудитын хороо нь 3 гишүүнээс бүрддэг ба хорооны нийт гишүүдийн 2/3-ыг хараат бус гишүүн бүрдүүлдэг. Тус Хорооны даргаар хараат бус гишүүн ажилладаг. Эрсдэлийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ын хурлаар хэлэлцсэн асуудлууд болон ТУЗ-ын Аудитын хорооноос хариуцан хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд, хорооны хурлаар хэлэлцсэн асуудал, хурлын ирцийн талаар компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тогтмол тусгаж СЗХ болон МХБ ХК-д тайлангаа жил бүр тогтоосон хугацаанд хүргүүлж цахим хуудсанд байршуулдаг.	2	100%

	<i>нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>				
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлдэг	Тайлант хугацаанд компани энэ чиглэлээр “Эрсдлийг тодорхойлох, сэргийлэх арга хэмжээг төлөвлөх журам”-ыг баталж энэхүү журмаар компанийн чиг үүргийн нэгж бүр үйл ажиллагааны гүйцэтгэлийн явцад бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт учирч болзошгүй эрсдлээ тодорхойлж, түүнээс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган, “Чанарын гарын авлага”-д тусгаж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Компанийн үйл ажиллагаанд эрсдлийн хүчин зүйлсийг 2 ангилсан. Үүнд: 1. Гадаад орчноос хамаарах 2. Дотоод үйл ажиллагаанаас хамаарах Эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг ажлын гүйцэтгэлтэй уялдуулах талаар чанарын багийн гишүүд, албадын дарга нар, менежерүүдэд сургалтаар танилцуулж өдөр тутмын ажлын зааварчилгаа өгч, эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөөг ажлын байр тус бүрт байршуулж, ашиглах боломжоор хангаж хяналт тавьж ажилласан.	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн Хэрэгжүүлдэг	2022 оноос эхлэн компанийн удирдлагаас компанийн үйл ажиллагаанд “ISO-9001-2015 чанарын менежментийн тогтолцоо”-г нэвтрүүлж эхэлсэн. ISO-9001 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх чиглэлээр компанийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа дүрэм, журам, заавар, гэрээ, албан бичигт болон явуулж буй үйл ажиллагаанд стандартын шаардлагын нийцлийг хангах ажлыг зохион байгуулж улмаар нийцлийг хэрэгжүүлж хэвшүүлсэн. Энэхүү ажлын үр дүнд компани нь Стандарт хэмжил зүйн төвийн Чанарын баталгаажуулалтын газраас “Магадлан итгэмжлэлийн баталгаажуулалтын аудит”-д орж сертификат авсан.	2	100%
ДҮН				7	%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр,		Компанийн ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 10.3.15, 12.2-т заасны дагуу Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл жилийн ажлын тайлангаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх, ХЭХ-аас ТУЗ-ын		

	<i>давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцээж батална.</i>	Бүрэн хэрэгжүүлдэг	ажлын тайланг ил тодоор хэлэлцэж ТУЗ-ын төсвийг баталдаг бөгөөд мөн журмын 12.4-т ТУЗ нь батлагдсан зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулдаг бөгөөд тайланг ТУЗ-ын нарийн бичгийн дарга гарган ТУЗ-ын хуралд танилцуулахаар зохицуулагдсан. ТУЗ-ын ажлын тайлангийн нэг үзүүлэлт нь ТУЗ-ын гишүүнд олгосон ТУЗ-ын хурлын цалин, урамшууллын төсөв байдаг ба ТУЗ нь ХЭХ-аас баталсан төсвийн дагуу ТУЗ-ын гишүүдэд цалин, урамшуулал олгодог. Компанийн ТУЗ нь жил бүр ТУЗ-ын гишүүдэд олгосон цалин, урамшууллын талаарх мэдээллийг компанийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж СЗХ болон МХБ ХК-д хүргүүлж Хөрөнгийн биржийн сайт болон компанийн өөрийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилладаг. 2025 оны ХЭХ-д 2024 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг тус тус танилцуулж 2025 оны ТУЗ-ын төсвийг хэлэлцүүлж батлуулсан.	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ын хурлаас “ТУЗ-ын Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийг баталсан. Тус журманд компанийн ТУЗ-ын гишүүд, Гүйцэтгэх удирдлага, түүний удирдлагын баг болон компанийн нийт ажилтнуудад компанийн үйл ажиллагааны чиглэл, онцлогт тохируулан мэргэжлийн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмж, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан олгох цалин, урамшууллын тогтолцоо, бодлого, хэрэгжүүлэх арга, хэлбэрийг тусгасан.	2	100%

24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн ТУЗ-ын үйл ажиллагааны журам"-ын 2.7.8, 8.1.6-д заасны дагуу ТУЗ нь компанийн Гүйцэтгэх захиралтай "Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ"-г байгуулж гэрээний дагуу болон жил бүрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас баталсан бизнесийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, борлуулалтын орлого, ажилласан хугацааг тус тус үндсэн шалгуур болгон Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлт гарган ТУЗ-ын дүгнэлтийн дагуу Гүйцэтгэх удирдлагад цалин, шагнал, бусад урамшууллыг олгож ирсэн бөгөөд 2023 оноос эхлэн компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний дүнг шалгуур үзүүлэлтэд нэмж тусгасан. Компанийн Гүйцэтгэх удирдлагад шагнал, урамшуулал олгохтой холбогдуулан компанийн "Жилийн үйл ажиллагааны тайлан"-д компанийн засаглал, санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол тусгаж тайланг СЗХ, МХБ ХК-д хүргүүлж, МХБ ХК-ийн болон компанийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилладаг. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд холбогдох мэдээллийг тусгаж тайлагнасан.	2	100%
ДҮН				6	100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ын хурлаас "Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг"-ийг баталсан. Компанийн "ТУЗ-ын үйл ажиллагааны журам"-ын 2.8.5, 2.8.7-д компаниас бусад оролцогч талуудтай хэрхэн харилцах, хамтран ажиллах талаар тусгагдсан байдаг. Компанийн холбогдох албан тушаалтнууд оролцогч талуудтай компанийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу хэрхэн ажилласан талаар 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж зохих журмын дагуу тайлагнаж ажилласан.	2	100%

26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компани нь “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг”-ийн дагуу болон ISO-9001 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагаанд компанийн Оролцогч талуудтай харилцахдаа Компанийн үнэт зүйлсэд нийцсэн үзэл баримтлал, зарчмыг мөрдлөг болгон тэдний хүсэлт, шаардлагад нийцүүлэн ажилласнаар харилцагч хэрэглэгчээ татаж, хамрах хүрээгээ өргөжүүлэх, ажил үйлчилгээний хурд, шуурхай байдал, хөдөлмөрийн бүтээмж дээшлэх, бараа материалын борлуулалт нэмэгдэх үндэс болсон. Компанийн холбогдох албан тушаалтнууд оролцогч талуудтай компанийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу хэрхэн ажилласан талаар 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж зохих журмын дагуу тайлагнаж ажилласан.	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн цахим хуудасны “Бидний тухай” ангилал хэсэгт компанийн болон охин компаниудын үйл ажиллагаа, зах зээлд нийлүүлж буй бараа материалын талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулж хөрөнгө оруулагч, оролцогч талуудад мэдээлэл хүргэж ажилладаг.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлдэг	1.Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх асуудлыг тусгайлсан журмаар зохицуулдаггүй ч компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3.2.5 дахь хэсэгт тусгаж зохицуулсан. 2. Компанийн ажилчдын нийгмийн асуудлыг “Техник импорт ХК-ийн ажилтнуудад нэмэгдэл, буцалтгүй тусламж, хөнгөлөлт, тэтгэмж олгох журам”-аар зохицуулдаг.	2	100%

			3.Компани нь өндөр бүтээмжийг бий болгох, бизнесийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах зорилгоор ажилтныг сургаж, хөгжүүлэх ажиллагааг “ Ажилтны сургалт хөгжлийн журам ”-аар зохицуулдаг. 4. Компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 12.1-т болон компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4 дүгээр зүйлд тус тус ТУЗ-ын болон Гүйцэтгэх удирдлагын ажлын төлөвлөгөөний талаар тодорхой тусгаж зохицуулсан.		
ДҮН				8	100%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлдэг	2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ын хурлаас “Ёс зүйн дүрэм”-ийг баталж компанийн цахим хуудсанд байршуулсан. Журмын хэрэгжилтэнд компанийн ТУЗ-аас хяналт тавьж ажиллаж байна. 2024 онд ТУЗ-аас журмын хэрэгжилтийг дүгнэж үзэхэд ТУЗ-ын гишүүд болон компанийн ажилтнуудаас ТУЗ-ын болон компанийн “Ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн үйлдэл гаргаагүй болно.	2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	Бүрэн хэрэгжүүлдэг	2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ын хурлаас “Ёс зүйн дүрэм”-ийг баталсан. “Ёс зүйн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.5-т тусгасан.	2	100%
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлдэг	Компани нь 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр анх удаа “Авлигатай тэмцэх хөтөлбөр”-ийг компанийн болон охин компаниудын хэмжээнд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд хөтөлбөр нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус хөтөлбөр нь компанийн бүх үйл ажиллагаа ил тод байж компанийн сайн засаглалыг бэхжүүлэх, компанийн хэмжээнд аливаа авилгын эсрэг тэмцэх бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, энэ талаар төрийн болон төрийн бус байгууллагууд, бусад компаниудтай хамтран ажиллах нөхцөл боломжийг хангахад чиглэсэн ба хөтөлбөрийн 2.1, 4.2-т авилга, албан тушаалын гэмт хэргээс ангид байх, улс төрийн аливаа үйл ажиллагаанд хандив өгөхгүй байх талаар тусгаж зохицуулсан.	2	100%

			2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн компанийн ТУЗ-ын хурлаас “Ёс зүйн дүрэм”-ийг баталсан. Авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх талаар “Ёс зүйн дүрэм”-ийн 2.5-д тусгаж зохицуулсан. 2024 онд холбогдох журмыг баримталж ажилласан болно.		
ДҮН				5,5	%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компани нь компанийн засаглалын бүтэц, зохион байгуулалт, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэл, ажлын явц, ажлын гүйцэтгэлийн үр дүн, төлөвлөгөөний биелэлт, компанийн засаглалыг хэрхэн хэрэгжүүлсэн эсэх талаарх мэдээллийг компанийн “Хагас болон жилийн үйл ажиллагааны тайлан”-д тодорхой, үнэн зөв тусгаж СЗХ болон МХБ ХК-д хүргүүлж МХБ ХК-ийн болон компанийн цахим хуудсанд байршуулах, компанийн цахим хуудасны “Бидний тухай”, “Мэдээ, мэдээлэл” хэсэгт компанийн болон үйл ажиллагааны чиглэл, бараа бүтээгдэхүүний танилцуулга, компанийн онцлог үйл явдлууд, компанийн засаглалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан баталсан журмууд, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг холбогдох хууль, журамд заасны дагуу болон цаг тухай бүрд нь мэдээлж нийтэд мэдээлэх үүргээ биелүүлж ажилладаг. Оролцогч талуудад хүргэх мэдээллийг зохих журмын дагуу хүргэж ажилласан.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солицох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу холбогдох мэдээллийг заасан хугацааны дотор Хороо болон Хөрөнгийн биржид тогтмол хүргүүлж ажилладаг бөгөөд Хөрөнгийн биржийн цахим хуудсанд компанийн үйл ажиллагааны талаарх журамд заасан мэдээллүүдийг тогтмол байршуулж олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажилладаг. Компани нь Хөрөнгийн биржээс гаргасан “Үүргийн хэрэгжилтийн судалгаа”-гаар 2012 онд 56%-тай дүгнэгдэж байсан бол 2023,2024 оны судалгаагаар 100 хувьтай дүгнэгдсэн.	2	100%

34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компанийн Дүрмийн 7.12,7.15,7.16,7.26, 7.28, 7.33,7.34, 7.35, 7.36,7.37-д мөн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 2.5.3,2.5.4,2.5.5, 9.2.7, 10.2.7,11.1, 11.2.4, 11.2.5 заалтуудаар зохицуулдаг. 2024, 2025 оны ХЭХ-ыг зарлан хуралдуулах ажлын хүрээнд компанийн хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах эрхийг нь хэрэгжүүлэх нөхцөл бололцоогоор хангаж ажилласан.	2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлдэг	Компани нь Компанийн тухай хууль, компанийн Дүрэм, ТУЗ-ын үйл ажиллагааны журам, СЗХ, Хөрөнгийн биржийн дүрэм, журамд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангаж ажилладаг.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлдэг	1.Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хэрхэн шийдвэрлэх талаар Компанийн “Дүрэм” болон “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 2.5.17, 2.6.5, 12.10, 13.3 дахь заалтуудаар зохицуулагддаг. 2. 2024 оны компанийн хагас болон жилийн үйл ажиллагааны тайланд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээллийг тогтмол тусгаж тайлагнасан.	2	100%
ДҮН				10	100%
НЭГДСЭН ДҮН				72	100%